**БАЯНХОНГОР АЙМАГ**
**БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/01 Булган

Албан тушаалын цалин нэмэгдлийг
шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 275 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын 2,9,11 дүгээр хавсралт, Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлыг мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах журам"-ын 3.1 дэх заалт, УИХ-н 2019 оны 21 дүгээр тогтоол "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын орлогч (Э.Жамсрандорж)-ийн албан тушаалын үндсэн цалинг 890013 төгрөг, Онцгой нөхцөлийн 30 хувь, Багийн Засаг даргын албан тушаалын үндсэн цалинг 645000 төгрөг, онцгой нөхцөлийн 30 хувь, Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын үндсэн цалинг ТЗ-9-4 шатлалаар 994629 төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Амгаланбаяр)-т Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 10 хувь, Аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн "Зэрэг дэв олгох тухай" А/253 дугаар захирамжийн дагуу Ахлах түшмэлийн дөтгөөр зэргийн нэмэгдэл 26 хувь, Улсын их хурлын байнгын хорооны 2012 оны 05 тоот тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын дагуу эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ын нэмэгдлийг 15

642101085

хувь, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын даргын 2016 оны 2б/155 тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу нууцын нэмэгдлийг 10 хувиар тооцон сар бүрийн цалин дээр тус тус нэмж бодож олгохыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Т.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3.Сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Самданжигмэд), Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Долгормаа), Соёлын төвийн эрхлэгч (Ж.Болдбаатар), Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч (Э.Уртнасан) нарын үндсэн цалин, нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Дүүрэнбилэг)-т даалгасугай.

ДАРГА Б.ИДЭРМӨНХ

Сумын Засаг даргын 2022 оны ...01... дүгээр сарын ...07... өдрийн ...11... тоот захирамжийн хавсралт

## АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЦАЛИНГИЙН НЭМЭГДЭЛ

| № | Овог нэр | Албан тушаал | Ажилласан жил | Засгийн газрын 382 дугаар тогтоолын 01 дугаар хавсралтаар олгох хувь | Цалин-гийн шатлал | Үндсэн цалин | Онцгой нөхцөлийн нэмэгдэл хувь | Засгийн газрын 382 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтаар олгох хувь | ЭБАТ-ын нэмэгдэл хувь | Мэргэжлийн зэргийн нэмэгдэл | Нуцын нэмэгдэл хувь | Ажил хавсаран гүйцэтгэж буй хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Энх-Амгалан Жамсрандорж | Засаг даргын орлогч | 4 жил | - | ТУТ | 890013 | 30% | - | - | - | - | - |
| 2 | Эрдэнэбат Амгаланбаяр | Тамгын газрын дарга | 13 жил | 10% | ТЗ-9-4 | 994629 | - | - | 15% | Ахлах түшмэл 26% | 10% | - |
| 3 | Нордог Батнасан | Багийн Засаг дарга | 5 жил | - | ТУТ | 645000 | 30% | - | - | - | - | - |
| 4 | Амгалан Бат-Эрдэнэ | Багийн Засаг дарга | 5 жил | - | ТУТ | 645000 | 30% | - | - | - | - | - |
| 5 | Батцоодол Гантулга | Багийн Засаг дарга | 4 жил | - | ТУТ | 645000 | 30% | - | - | - | - | - |
| 6 | Мөнхтуяа Жамъяндорж | Багийн Засаг дарга | 2 сар | - | ТУТ | 645000 | 30% | - | - | - | - | - |
| 7 | Жамба Болдбаатар | Соёлын төвийн эрхлэгч | 15 жил 3 сар | 10% | ТҮСУ-5-5 | 895945 | | 15% | | - | | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Эрдэнэбат Уртнасан | Эрүүл мэндий н төвийн эрхлэгч | 7 жил | 5% | ТҮЭМ-6-5 | 934899 | | 20% | | - | | 40% Хүүхдийн эмч |
| 9 | Дорж Долгормаа | Цэцэр-лэгийн эрхлэгч | 30 жил 6 сар | 25% | ТҮБД-5-5 | 964899 | | 15% | | 10% | | - |
| 10 | Батбаяр Самданжигмэд | Сургуу-лийн захирал | 4 жил 4 сар | - | ТҮБД-5-3 | 912097 | | 15% | | - | | - |